

”Финанс линк групп” ХХК-д брокер, дилер,
андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1, 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалтууд болон “Финанс линк групп” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2007 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.”Финанс линк групп” ХХК-д үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2.Хөрөнгө оруулагчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг ”Финанс линк групп” ХХК /Д.Туул/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ